



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 649

Улаанбаатар хот


“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
журам батламжлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 373 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2018/15 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ыг батламжилсугай.

2. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын эрх ашгийг хамгаалах, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН